

ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЯПОН СУДЛАЛЫН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ: УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Б.СЭРЖАВ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
доктор (Ph.D), дэд профессор

У.ЗАГДЦЭСЭМ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
эрдэм шинжилгээний дэд ажилтан, докторант

Товч агуулга: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын тасаг нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үйл явц, түүний тулгамдсан асуудал, хөгжлийн стратегитай холбогдуулан хүрээлэнгийн судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд Япон Улс дахь Монгол судлал, Монгол-Японы харилцааны түүхийн судалгаа, Япон Улсын эдийн засгийн өндөр өсөлтийн түүх, сургамж туршлага зэрэг судалгаанд анхаарал хандуулсаар ирсэн юм. Энэхүү илтгэлд тус хүрээлэнгийн Япон судлалаар хийгдэж ирсэн судалгааны уламжлал шинэчлэлийн асуудал, судалгааны үр дүнгээр нийтлэгдсэн нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл, ном товхимлын талаар голлон товч танилцуулахын зэрэгцээ сүүлийн үед Япон Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн бодлого, эдийн засгийн хөгжлийн талаарх судалгааг олон талаас нь хөндөн авч үзэх болно.

Түлхүүр үгс: Олон улс судлалын хүрээлэн, Япон дахь Монгол судлал, Монгол-Японы харилцаа, Японы хөгжлийн туршлага, Монгол Улсын хөгжлийн стратеги, зорилт

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн эдүгээгээс 55 жилийн өмнө буюу 1968 онд Ази, Африк судлалын хэлтэс нэртэйгээр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд үүсэн байгуулагдах үеэс тус байгууллагын судалгаа шинжилгээний ажил манай улсын тухайн үеийн гадаад, дотоод бодлого, олон улсын харилцааны чиг хандлагатай уялдан Хятад судлалыг

голлож байсны зэрэгцээ хүрээлэнд япон хэлтэй түүхч, япон судлаачид болох Ц.Хандсүрэн, Д.Дүнгэр-Яйчил, Б.Түмэнжаргал нар ажиллаж, хүрээлэнгийн Япон судлалыг эхлүүлж байсан түүхтэй.

Түүнчлэн, Дорно дахины судлалын хүрээлэн 1978 оноос “Дорно дахины судлалын асуудал” нэртэй сэтгүүл эрхлэн гаргах болсон нь 1990-ээд он хүртэл Азийн улс оронтой холбоотой судалгааны материал нийтэлдэг цорын ганц мэргэжлийн, академик хэвлэл байв. Өөрөөр хэлбэл, 1990 оноос өмнөх тус хүрээлэнгийн Япон судлал төдийгүй манай улсын Япон судлалын ерөнхий дүр төрх, чиг хандлагыг “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүлийн агуулгаас тусган харж болохоор байдаг. Уг сэтгүүлд Япон дахь Монгол судлалын асуудалд анхаарал хандуулсан эрдэм шинжилгээ, сурталчилгааны цөөн бус өгүүлэл нийтлэгдсэн байгаагаас дээр өгүүлсэн тухайн үеийн Япон судлалын ажлын зорилго, чиглэлийг ойлгож болно.

Япон Улсын эрдэмтэд судлаачид ХХ зууны эхэн үеэс Монгол судлалыг түүх, улс төр, эдийн засаг, хэл, соёл зэрэг олон салбараар явуулж, эрдэм шинжилгээний арвин их бүтээл туурвиж, олон улсын хэмжээнд монгол судлалын тэргүүлэх томоохон төв болжээ. Япон дахь Монгол судлалын ийм ололт нь манай улсын Япон судлалд ч ахиц гарахад тодорхой нөлөө үзүүлжээ. Эхний үед хүрээлэнгийн судалгааны хүрээнд Япон улсад хийгдэж буй монгол судлалын ажил, Японы монголч эрдэмтдийн туурвисан гол гол бүтээлийг судалж, танилцуулахад анхаарал хандуулж, 1988 онд “Хятад, Япон дахь Монгол судлалын тоймоос” (ред. Ч.Далай, Д.Дүнгэр-Яйчил, ШУА-ийн хэвлэл, УБ., 1988) хамтын бүтээл нийтийн хүртээл болсон юм.

Мөн судлаачдын санаачилгаар Дорно дахины судлалын хүрээлэнгийн дэргэд 1989 онд Япон судлалын төв байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн нь манай улс дахь Япон судлалын чиглэлийн анхны төрийн бус, олон нийтийн байгууллага байв.

Манай улсад эдийн засаг, улс төрийн тогтолцоо өөрчлөгдөн шинэ нийгэмд шилжсэн 1990-ээд онд Олон улс судлалын хүрээлэн Япон судлалын залуу боловсон хүчнээр харьцангуй бэхжиж, Монгол-Японы соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Япон Улсад залуу судлаачдыг илгээн мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг өргөтгөх, чанар агуулгыг гүнзгийрүүлэх чиг бодлогыг түлхүү баримтлан ажиллаж байжээ. Эхний үед судалгааны тэргүүлэх чиглэлийг Япон Улсад Монгол судлалын ажил хэрхэн явагдаж буйг судлан танилцуулахаас эхэлж, аажмаар Монгол-Японы харилцааны түүх, орчин үеийн чиг хандлага, Япон Улсын нийгэм, эдийн засаг, гадаад бодлогын асуудал, Японы уламжлалт соёл, эдийн засгийн бүтэц, хөгжлийн туршлага, эдийн засгийн хөгжилд нөлөөлсөн хүчин зүйл, Япон Улстай

тогтоон хөгжүүлж буй хамтын ажиллагаа, зээл тусламжийн судалгааг хэрэгжүүлэхэд чиглүүлж иржээ.

1990 оноос Монгол Улс хөгжлийн шинэ гарааг эхлүүлж, Япон Улстай харилцах харилцаа үсрэнгүй хурдцаар урагшлан олон салбарын хамтын ажиллагааны агуулга, цар хүрээ өргөжин тэлж, хоёр орны харилцааны цоо шинэ шат эхэлсэн байна. Үүнтэй зэрэгцэн Монголын олон нийт, оюутан залуусын дунд япон хэл, Япон орныг сонирхох байдал эрс дээшилсэн нийгмийн эрэлт шаардлагын дагуу Дорно дахины судлалын хүрээлэнгийн Япон судлалын ажлын хүрээг өргөжүүлэн Монгол-Японы харилцаа, Япон орон судлал, япон хэл, толь бичиг судлал, Японы хөгжлийн туршлага, Азийн бар орнуудын хөгжлийн амжилтад анхаарал хандуулах болсон юм. Хүрээлэнгийн судлаачид 1991 онд "Япон орон, япончууд" (Улсын хэвлэлийн газар, УБ., 1991) гэдэг жижиг товхимол хэвлүүлсэн нь манай орны нийгмийн өөрчлөлт шинэчлэлт эхэлсэн цаг үед Япон орны түүх, соёл, өнөөгийн хөгжлийн талаар бодит мэдээлэл өгөх зорилго тавьсан ажил болсон бол Л.Бадамрагчаа, Б.Сэржав нарын зохиосон "Япон хэл (эхлэн сурах бичиг)" (Эрдэм хэвлэх үйлдвэр, УБ., 1991), 1999 онд хэвлэгдсэн Араи Шиничи, Б.Сэржав "Япон-Монгол толь" (УБ., 1999) нь япон хэл сонирхон суралцагсдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээл болсон юм.

Дорно дахины судлалын хүрээлэн 1991 онд Зүүн хойд Ази судлал болон Дорно дахины судлалын чиглэлээр хоёр байгууллага болон салж, аль алинд нь Япон судлалын ажил явагдан үр дүнд нь "Зүүн хойд Ази судлал", "Дорно дахины судлалын асуудал", "Дорно-Өрнө" сэтгүүлүүд нийтийн хүртээл болж байв. Харин 1999 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр Олон улс судлалын хүрээлэн эргэн байгуулагдаж, улмаар 2015 оноос Олон улсын харилцааны хүрээлэн, 2021 оноос Олон улс судлалын хүрээлэн нэртэйгээр судалгаа шинжилгээний ажлаа хэрэгжүүлж байна. Тус хүрээлэнгийн судлаачид 1990-ээд оноос Монгол-Японы харилцааны судалгаанд анхаарал хандуулж, уг сэдвийг дагнан хөндсөн нэгэн сэдэвт бүтээл, өгүүллийн эмхэтгэл нийтлүүлж олны хүртээл болгож ирлээ. 1998 онд хэвлэгдсэн "Монгол, Японы харилцаа: Эрт, эдүгээ" (Эрүүл мэнд хэвлэлийн үйлдвэр, УБ., 1998) эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл нь Монгол-Японы харилцааны сэдвийг дагнан авч үзсэн анхны хамтын бүтээл болсон бөгөөд хоёр орны харилцааны түүх хийгээд түүнд холбогдох сурвалж бичиг, харилцаа хамтын ажиллагааны орчин үеийн байдал, цаашдын төлөв, чиг хандлагыг тусгасан өгүүлүүд багтсан юм.

Мөн академич Ц.Батбаярын туурвисан "Кодама, Мицуи пүүс, Хүрээнд байсан япончууд (1911-1921 он)" ("Эрдэм" хэвлэлийн компани, УБ., 1993), "Монгол ба Япон XX зууны эхний хагаст" ("Адмон" хэвлэлийн компани, УБ., 1998), "Монгол ба Япон XX-XXI зуунд: "Гуравдагч хөрш"-ийн харилцааны

түүх" (Ред. Б.Сэржав, "Бэмби сан" хэвлэлийн компани, УБ., 2022) доктор Б.Сэржавын "Монгол-Японы харилцаа: ХХ зууны сүүлийн хагаст" ("Өргөө" хэвлэлийн компани, УБ., 2003) зэрэг нэг сэдэвт зохиол, "Монгол-Японы харилцаа: өнгөрсөн ба эдүгээ (ХХ зуунд)" ("Бэмби сан" хэвлэлийн газар, УБ., 2011) олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, "Олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаачдын япон хэлээрх өгүүллийн эмхэтгэл" ("Тод бичиг" хэвлэлийн компани, УБ., 2016), "Монгол-Японы харилцаа: Он дарааллын товчоон 1972-2022" ("Бэмби сан" хэвлэлийн газар, УБ., 2022), "Монгол-Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022" ("Соёмбо принтинг" хэвлэлийн компани, УБ., 2022) зэрэг хамтын бүтээл, судалгааны эмхэтгэл нийтлүүлэн олны хүртээл болгожээ.

Манай улсаас Япон улстай тогтоон хөгжүүлж ирсэн харилцаа, хамтын ажиллагааны түүх, өнөөгийн байдлын судалгааны хүрээнд тус хүрээлэнгийн эрдэмтэд судлаачид олон арван тооны өгүүллийг бичиж нийтлүүлсэн юм. Эдгээр нэгэн сэдэвт зохиол, товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл, эмхэтгэл нь Монгол-Японы харилцааны эрт, эдүгээгийн бүдэг маргаантай асуудлыг архивын хэрэглэгдэхүүн, сурвалжийн мэдээ баримт, гадаадад хэвлэгдсэн судалгааны бүтээлд түшиглэн тодруулж, үнэлэлт дүгнэлт хийснээрээ энэ салбарын судалгааг гүнзгийрүүлэхэд ач холбогдлоо өгсөн байна. Эдгээр судалгааны үр дүнд манай улсаас Япон улстай тогтоон хөгжүүлж ирсэн харилцааны түүх нь тус хүрээлэнгийн Япон судлалын хүрээнд харьцангуй нэлээд судлагдсан сэдвийн нэг болж байна.

Олон улс судлалын хүрээлэн 1990-ээд оноос "Япон Азийн "барс" үсрэнгүй хөгжсөн нь" ("Сүхбаатар" хэвлэлийн компани. УБ., 1994), "Зүүн хойд Ази: Эдийн засгийн хамтын ажиллагаа" (УБ., 1995), "1990-ээд оны үеийн олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс их гүрнүүдийн харилцаа" ("Сүхбаатар" хэвлэлийн компани, УБ., 1995), "Монгол Улс ба Зүүн хойд Ази" (УБ., 2002), "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд: Өнөө, ирээдүй" (Ред. Доктор С.Дашцэвэл, УБ., 2002) зэрэг хамтын бүтээл гаргасан нь Япон судлалын хүрээг тэлэхэд ач холбогдолтой болсон юм.

Монгол Улсад өрнөсөн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг тууштай дэмжиж, олон талын тусламж дэмжлэгийг тогтвортой үргэлжлүүлж ирсэн Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, нийгмийн бүх салбарын олон талт тусламж дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт нь шилжилтийн үеийн бэрхшээлийг давахад нэн чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Манай хүрээлэнгийн судлаачид "Японы хөрөнгө оруулалт, зээл тусламж, түүний үр ашиг" (Ред. Доктор (Sc.D) Ц.Баатар, "Бэмби сан" хэвлэлийн газар, УБ., 2004) хамтын бүтээлийг уншигчдын хүртээл болгосон нь Япон Улсын зээл тусламж, хөрөнгө оруулалтын үйл

явцад анхаарал хандуулан түүний ашиглалт, үр дүнг шинжилж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид олон талт хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж эрчимжүүлэх арга зам, Монголын хөрөнгө оруулалтын орчин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, эерэг сөрөг тал зэрэг асуудлыг хөндөн судлах оролдлого хийснээрээ шинэлэг, тодорхой асуудлыг дэвшүүлсэн судалгааны ач холбогдол бүхий ажил болжээ.

Тус хүрээлэнд хийгдэж буй Япон судлалын ажлын нэгэн чиглэл нь сүүлийн үед Монгол Улсын хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, үйлдвэржилтийг урагш ахиулахад тус болохуйц гадаад хүчин зүйлийн хувьд Японы хөгжлийн туршлагыг судлан танилцуулах, судлаачдын санал, дүгнэлтийг хамтын бүтээл, судалгааны өгүүлэл, илтгэл болон бусад хэлбэрээр бодлого боловсруулах байгууллага болон олон нийтэд хүргэх зорилт тавьж ажиллаж ирлээ. Тухайлбал, 2014 онд хэвлэгдсэн "Японы менежмент, жижиг дунд үйлдвэр: Хөгжлийн туршлага" (Ред. Доктор Ц.Даваадорж, "Тод бичиг" хэвлэлийн компани, УБ., 2014) хамтын бүтээл нь Японы менежментийн хөгжил, аж үйлдвэрийн соёл, удирдлагын арга барилын талаар, мөн Япон улсад жижиг дунд үйлдвэрийн бодлогыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үе шат бүрийн онцлогт нийцүүлэн ард түмний аж амьдралын түвшнийг дээшлүүлэхэд гүйцэтгэх үүргийг чухалчлан үзсэний үндсэн дээр системтэйгээр боловсруулан хэрэгжүүлж ирсэн туршлага, улс орны эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзэлж буй байр суурь, хөгжлийн түүх хийгээд өнөөгийн байдал зэргийг судлан танилцуулахын зэрэгцээ Япон улсын хүний хөгжлийн бодлогын зарим хэсэг, тухайлан залуу үеийг хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгаж, хэрэгжүүлж ирсэн туршлагаас танилцуулж, манай улсын онцлогт тохируулан тусган авч хэрэглэж болох талаар санал дүгнэлт дэвшүүлсэн шинэлэг ажил болсон юм.

Мөн орчин үед дэлхий дахинаа хөгжил дэвшлийн хамгийн оновчтой загвар хэмээн томъёологдож ирсэн "ногоон хөгжил"-ийг Япон улсад хэрхэн хэрэгжүүлж ирсэн талаарх судалгааг Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр 2014-2016 онд хэрэгжүүлж, Япон Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны асуудлыг тэнцвэртэйгээр авч үзэж буй туршлагыг эдийн засгийн хөгжлийн үе шатуудад хэрэгжүүлсэн бодлого, ногоон инновацын чиг хандлага, байгаль экологи, эрчим хүч, агаар, ус, хөрс, хог хаягдлын салбарын болон хот төлөвлөлт, экологийн аялал жуулчлал, байгаль орчны боловсролын чиглэлээр хийсэн судалгааны үр дүнг танилцуулж, манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд тусган авч хэрэглэж болох туршлагын талаар судлаачдын санал дүгнэлтийг дэвшүүлсэн "Японы ногоон хөгжлийн туршлага" (Ред.

Доктор (Sc.D) Ц.Баатар, "Тод бичиг" хэвлэлийн компани, УБ., 2017) хамтын бүтээлийг нийтлүүлэв. Япон улсад төрийн бодлогын залгамж шинж, нэгдмэл, цогц байх зарчим чанд үйлчилдэг, бодлого боловсруулах болон төлөвлөлтийн бүхий л үйл явцыг цаг хугацааны дэс дараалалтай, экологийн хүчин зүйлтэй нягт уялдуулан зохион байгуулдаг, түүнийг нийгмийн бүхий л салбарт үе шаттайгаар хэрэгжүүлдэг, нэгэнт тогтоосон хууль, дүрэм журмыг иргэд нь амьдрал үйл ажиллагаандаа тууштай мөрдөн хэвшүүлдэг зэрэг туршлагыг энэ хамтын бүтээлд хөндөн авч үзэх оролдлого хийсэн. Япон улсын хурдацтай хөгжлийн туршлагыг судлан, оновчтой туршлагыг өөрийн орны онцлогт тохируулан, нарийн судалгаа тооцооны үндсэн дээр урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад нутагшуулан авч ашиглах нь манай улсын хөгжил дэвшилд түлхэц үзүүлэх чухал хүчин зүйл байх нь маргаангүй. Тиймээс судалгааны үр дүнгээр төрийн байгууллага, бодлого боловсруулагчдад зориулсан "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын зөвлөмж (Японы жишээн дээр)", "Япон улсын хог хаягдлын талаарх хууль эрх зүйн орчинд хийсэн судалгааны хураангуй танилцуулга, зөвлөмж", "Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаахад Монгол Улсын үүрэг оролцоо", "Японы бага сургуульд ёс зүйн боловсрол олгож буй туршлагаас" зэрэг санал, бодлогын зөвлөмжийг бэлтгэж, Хөдөлмөрийн яам Жижиг дунд үйлдвэрийн газар, БОНХЯ Ногоон хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин ногоон хөгжлийн газар болон Улаанбаатар хотын Захирагчийн албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар, Гадаад харилцааны яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын хэрэгцээнд тус тус хүргүүлсэн нь манай улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд тустай ажил болсон гэж үзэж байна.

Монгол Улс Япон улсын харилцаа, хамтын ажиллагаа 1990-ээд оноос хойш эрчимтэй хөгжиж, 1998 оноос Иж бүрэн түншлэлийн харилцаа, 2010 оноос Стратегийн түншлэлийн харилцаа, 2022 оноос Тусгай стратегийн түншлэлийн харилцааны шатанд дэвшин, Япон улс нь манай улстай Тусгай стратегийн түншлэлийн харилцаа бүхий анхны улс болж буй үйл явц нь манай улс дахь Япон судлалын ажлыг эрчимжүүлэх, судалгааг гүнзгийрүүлэх шаардлагыг бий болгосоор байна. Мөн 2016 онд хоёр орны засгийн газар хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдан хэрэгжиж эхлээд багагүй хугацааг өнгөрөөгөөд байна. Хүрээлэнгийн япон судлалын баг манай улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, хөгжлийн зорилт, чиг бодлоготой уялдуулан Япон улсын хүчин зүйлийг тодруулан судлах, тухайлан Монгол Улс, Япон улсын эдийн

засгийн хамтын ажиллагааны боломжид эрэл хайгуул хийх, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд судалгааны үр дүнгээр тус дөхөм үзүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон улстай тогтоон хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг” (2021-2023 он) судалгааны ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Энд тэмдэглэхэд, манай улсаас Япон улстай тогтоон хөгжүүлж ирсэн харилцаа, хамтын ажиллагаа, олон салбарын солилцооны үр дүн нь Японы хөгжлийн туршлагыг судлан нэвтрүүлж үр шимийг нь хүртэх боломжийг бий болгож байгаа бөгөөд Японы хөгжлийн туршлага болон бусад хүчин зүйлсийг манай улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилгод нийцүүлэн үр дүнтэй ашиглах нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг улам урагшлуулахад ч үр нөлөөгөө үзүүлнэ.

Цаашид бид уламжлалт судалгааг гүнзгийрүүлэхийн хамт орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлага, Япон улсын олон улсын тавцанд эзэлж буй байр суурь, нөлөө зэрэг хүчин зүйлсийг харгалзан хоёр орны харилцааны түүхэн хөгжил, манай улсын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн талаас нь анхаарал хандуулж, Японы улс төр, эдийн засгийн бодлого, бүтцийн өөрчлөлт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөгжлийн туршлагыг гүнзгийрүүлэн судлах, судалгааны ажлыг Монгол Улсын нийгэм эдийн засгийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, улс орны хөгжлийг түргэтгэх асуудалтай уялдуулан хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Ашигласан материал

1. Б.Сэржав “Япон судлал: Өнөөгийн байдал, цаашдын хандлага” Олон улс судлал сэтгүүл, 2006, №2
2. Т.Мөнхцэцэг “Монгол дахь Япон судлал” Адмон хэвлэлийн компани, УБ., 2007,
3. Монгол Улсын Шинжлэх Ухаан, Боть 45. Монгол дахь олон улс судлал. “Согоо нуур” хэвлэлийн компани, УБ., 2008,
4. Б.Сэржав, У.Загдцэсэм “Олон улсын харилцааны хүрээлэнгийн Япон судлалын өнөөгийн байдал, цаашдын зорилт” “Монголын япон хэлний боловсрол” Эрдэм шинжилгээний бичиг, №3, 2018,
5. Т.Мөнхцэцэг, У.Загдцэсэм “Монгол дахь япон судлалын шинэ чиглэл хандлага” Ази судлалын олон улсын эрдэм шинжилгээний IY хурлын эмхэтгэл, ICAS 2018.